



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ШИНЖЛЭХ УХААНЫ ОЛОЛТ НЭВТРҮҮЛЭХ ТӨВ
УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудит

Аудитын код: САГ-2020/32/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа

Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор: Ч.Дашдаваа

Утас: 260512 Цахим хаяг: dashdavaach@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Конфиденсе аудит” ХХК

Утас: 322431 Цахим хаяг: info@confidenceaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Аудитын гэрчилгээ	2
Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал.....	9
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын Төсөвт Үйлдвэрийн Газар
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам
ХААҮШУОНТ	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв
ХХААХҮС	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн сайд

Аудитын гэрчилгээ

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ШИНЖЛЭХ УХААНЫ ОЛОЛТ НЭВТРҮҮЛЭХ ТӨВ УТҮГ-ЫН ЗАХИРАЛ Р.ЦОГТБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй

нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Р.Цогтбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Конфиденсе Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ “Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны хүрээнд дэвшилтэд техник технологи дамжуулах,

нэвтрүүлэх, зуучлах, эрэлтэд нийцсэн сургалт зохион байгуулах, судалгаа хийх, эрдэм шинжилгээний шинэ бүтээл туурвих, мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлсон байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх сургалт явуулах
- Мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ –ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 14 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас

жилийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 225,846.7 мянган төгрөгөөс тооцон 2,258.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 12,366.2 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд 2019 оны хагас жилийн тайланг авсан гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн тайлангийн дүнг авсантай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 538,028.4 мянган төгрөгөөр буюу 45.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, өр төлбөр, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,512.7	10.0	-7,502.1
Авлага	0.0	75,075.5	75,075.5
Урьдчилгаа	0.0	2,200.0	2,200.0
Бараа материал	22,798.5	71,616.8	48,818.3
Үндсэн хөрөнгө	1,157,003.6	500,384.1	-656,619.5
Нийт хөрөнгө	1,187,314.8	649,286.4	-538,028.4
Өр төлбөр	0.0	30,683.5	30,683.5
Өмч	1,187,314.8	618,602.9	-568,711.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,187,314.8	649,286.4	-538,028.4

Авлага дансны үлдэгдэл өссөн нь төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдэл төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны төгсгөлд 65,625.0 мянган төгрөгийн ном хэвлүүлснээс шалтгаалж бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн байна.

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний “Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх” тогтоолын дагуу оффисын байраа шилжүүлж 675,122.1 мянган төгрөгөөр данснаас хассан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн А2/2257 тоот зөвшөөрлөөр 12,469.4 мянган төгрөгийн хөрөнгө, 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 301 тоот тогтоолын дагуу 8,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус акталсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А-1/4382 тоот шийдвэрээр 43,000.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Биет бус хөрөнгө худалдан авсан санхүүгийн онлайн программ, веб сайт, сургалтын тусгай зөвшөөрлийн дүн буюу нийт 4,600.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 7 сарын 22-ны өдрийн 301 дугаар тогтоолын дагуу 12,100.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг акталсан байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас Lovol 5 маркийн тракторыг 7 жилийн хугацаатай, 2 хувийн хүүтэй зээлээр худалдан авснаас шалтгаалан 30,683.5 мянган төгрөгийн өр үүссэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөрт зориулан 275,868.4 мянган төгрөгийг урсгал зардлын төсөв батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Гадаад төсөл хөтөлбөр болох Швейцарын Хөгжлийн агентлагаас 134,400.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 218,948.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 217,298.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 75,075.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 188 дугаар тогтоолд заасны дагуу ХХААХҮС-ын 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А/130 дугаар тушаалаар ХААҮШУОНТ ТӨААТҮГ-ыг татан буулгах ажлын хэсэг томилогдож, УТҮГ болсон. Орлого үр дүнгийн тайлангийн 2018 оны зэрэгцүүлэгдэх дүнд санхүүгийн үр дүнгийн тайланг төсөвт улсын үйлдвэрийн газар байх үеийн мэдээллийг оруулж тайлагнасан.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 30 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 85,249.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 69,454.6 мянган төгрөгийн алдааг залруулж 15,794.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2019 оны төсөв нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 188 дугаар тогтоолоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдын багцын “бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж” гэсэн ангилалд батлагдсан. 2020 оны аудитын тайлангаар энэ асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаа хоцроож өссөн дүнгээр 2019 оны 12 дугаар сард байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Үндсэн хөрөнгийн элэгдлийн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийг ашиглалтын хугацааны нь туршид шулуун шугамын аргаар тогтмол дүнтэй элэгдүүлэхээр ХХААХҮС-ын багцын төсөвт байгууллагын НББ-ийн бодлогын баримт бичигт заасан. Тавилга эд хогшил, тоног төхөөрөмж дансдын тайлант үеийн элэгдлийг нийт 9,386.4 мянган төгрөгөөр бага тооцоолсон байна.

3.1.2 Эрсдэл:

Тайлант үеийн элэгдэл илүү тооцоологдож, үр дүн буруу илэрхийлэгдсэн.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид элэгдлийг НББ-ийн бодлогын баримт бичигт заасны дагуу зөв тооцож бүртгэж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

1. Жолоочийн тооцооны хуудсыг ашиглаж шатахууны зарцуулалтыг гаргаагүй ба жолоочтой тооцоо боддоггүй.
2. Засгийн газрын 2015 оны 184 дүээр тогтоолд зааснаар үйлчлүүлэгч байгууллага 2500 см³-ээс дээш цилиндрийн багтаамжтай машиныг хот дотор ашиглахааргүй байна. Тус байгууллага 4500 см³ багтаамжтай Ланд круйзер 100 машиныг зарим өдрүүдэд хот дотор ашиглаж 377.1 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

3. Тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний сангаас үйлчлүүлэгчийн нэр дээр бүртгэлтэй 2 тээврийн хэрэгсэлд торгууль байгаа эсэхийг шалгаж үзэхэд нийт 956.2 мянган төгрөгийн торгуулийг төлөөгүй байгаа мэдээлэлтэй байна.

3.2.2 Эрсдэл:

1. “Жишиг норм батлах тухай” Дэд бүтцийн сайдын 2004 оны 1 дүгээр сарын 29-ний 19 дугаар тоот тушаалын 1 дүгээр хавсралтаас хэтрүүлэн зарцуулах магадлалтай.
2. “Суудлын автомашины ашиглалтын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.
3. Дээрх торгуулийг төлөх хариуцагчийг тодорхойлж төлөгдөөгүй торгуулийг яаралтай барагдуулах шаардлагатай байна.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

1. Жолоочийн тооцооны хуудас, Дэд бүтцийн сайдын 2004 оны 1 дүгээр сарын 29-ний 19 дугаар тоот тушаалын 1 дүгээр хавсралтын холбогдох үзүүлэлт зэргийг үндэслэн тухайн сарын шатахууны зарцуулалтын дүнг гаргаад, түүнийгээ тухайн сарын бодит зарцуулалттай харьцуулж хэтрэлт хэмнэлтийг гаргаж байх хэрэгтэй. Шатахуун зарцуулалт нь тооцооллоос хэтэрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авч ажилладаг байхыг зөвлөж байна.
2. Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөж Ланд круйзер 100 машиныг хот дотор унахгүй байхыг зөвлөж байна.
3. Сар бүрийн эцэст дээрх сайт руу орж торгууль байгаа эсэхийг шалгаж торгуулийн өргүй байхыг зөвлөж байна.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4 Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

2019 оны санхүүгийн тайлангийн биет бус хөрөнгийн бүлэгт 2018 оноос өмнө ашиглаж байсан 1,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Leader программ бүртгэлтэй байна.

3.3.2 Эрсдэл:

Цаашид ашиглахгүй биет бус хөрөнгийг данснаас хасахгүйгээр элэгдүүлэх эрсдэлтэй байна.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох тушаал зааврыг гаргуулан авч нэмж элэгдэл тооцохгүйгээр данснаас хасах шаардлагатай.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана. Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>30,311,228.91</u>	<u>148,902,320.75</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,512,728.91	10,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,512,728.91	10,000.00
3121	Төгрөг	7,512,728.91	10,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	7,512,728.91	10,000.00
33	АВЛАГА	-	75,075,548.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага		75,075,548.00
34	УРЬДЧИЛГАА	-	2,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал		2,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	22,798,500.00	71,616,772.75
35300	Бэлэн бүтээгдэхүүн	10,370,000.00	57,367,750.00
354	Хангамжийн материал	12,428,500.00	14,249,022.75
35410	Бичиг хэргийн материал		311,500.00
35420	Аж ахуйн материал	12,428,500.00	13,852,522.75
35440	Түлш, шатах тослох материал		85,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,157,003,644.12</u>	<u>500,384,111.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,157,003,644.12	500,384,111.76
392	Биет хөрөнгө	1,124,470,310.79	462,717,445.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,028,746,514.40	377,069,836.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	16,995,258.39	41,099,728.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,080,900.00	141,080,900.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	76,625,557.00	124,844,762.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	102,375,268.20	142,822,737.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	39,764,324.32	48,059,770.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,673,625.62	48,204,261.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	32,020,857.72	32,456,028.91
393	Биет бус хөрөнгө	32,533,333.33	37,666,666.60
39301	Програм хангамж	13,100,000.00	2,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	12,566,666.67	666,666.71
39303	Бусад биет бус хөрөнгө	32,000,000.00	36,600,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		766,666.69
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,187,314,873.03</u>	<u>649,286,432.51</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	<u>32,307,672.43</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	32,307,672.43
413	Өглөг	-	32,307,672.43
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		520,595.24
41350	Зээлийн хүүгийн өглөг		262,703.12
4136	Бусад өглөг	-	31,524,374.07
41361	Байгууллагад төлөх өглөг		31,524,374.07
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,187,314,873.03</u>	<u>616,978,760.08</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,187,314,873.03	616,978,760.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,140,849,243.29	1,140,849,243.29

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” УТҮГ-ын 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51101	Өмч: - төрийн	1,108,849,243.29	1,108,849,243.29
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	32,000,000.00	32,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	(21,364,782.26)	(523,870,483.21)
51210	Өмнөх үеийн үр дүн		(21,364,782.26)
51220	Тайлант үеийн үр дүн	(21,364,782.26)	(502,505,700.95)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	67,830,412.00	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,187,314,873.03</u>	<u>649,286,432.51</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	33,879,391.88	667,907,100.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,879,391.88	173,090,300.42
120	Нийтлэг татварын бус орлого	364,391.88	173,090,300.42
120002	Хүүгийн орлого	39,478.89	87,038.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	173,003,261.56
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	324,912.99	866,522.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		165,567,295.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		6,569,444.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,515,000.00	494,816,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	275,868,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		275,868,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,515,000.00	218,948,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,515,000.00	218,948,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	55,244,174.14	580,534,998.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,244,174.14	580,534,998.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,244,174.14	577,525,602.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,552,128.00	182,870,295.10
210101	Үндсэн цалин	9,552,128.00	145,436,099.78
210102	Нэмэгдэл		13,294,055.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт		15,366,000.00
210104	Урамшуулал		2,423,746.55
210105	Гэрээт ажлын хөлс		6,350,392.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,085,499.29	22,432,871.91
210201	Тэтгэврийн даатгал	1,085,499.29	17,819,219.37
210202	Тэтгэмжийн даатгал		1,168,592.16
210203	ҮОМШӨ-ний даатгал		518,815.19
210204	Ажилгүйдлийн даатгал		649,775.48
210205	Эрүүл мэндийн даатгал		2,276,469.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,975,420.00	14,591,979.00
210301	Гэрэл, цахилгаан	174,231.00	1,418,869.00
210302	Түлш, халаалт	1,801,189.00	12,867,852.00
210303	Цэвэр, бохир ус		305,258.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,259,666.00	11,605,889.00
210401	Бичиг хэрэг	926,000.00	1,825,650.00
210402	Тээвэр, шатахуун	148,250.00	5,408,467.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	185,416.00	2,126,412.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		55,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		448,110.00
210408	Бараа материал акталсны зардал		1,741,300.00
2105	Нормативт зардал		100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,118,550.00	13,450,700.00

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	2,118,550.00	13,450,700.00
2107	Томилолт, зочны зардал		3,865,733.48
210702	Дотоод албан томилолт		3,865,733.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,520,300.00	240,081,103.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,520,300.00	236,829,501.01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		576,298.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		287,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		83,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		614,500.00
210807	Газрын төлбөр		128,800.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		62,004.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,732,610.85	88,527,031.34
210901	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	1,761,119.46	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		5,053,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,971,491.39	83,473,631.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,009,395.18
2132	Бусад урсгал шилжүүлэг		500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		2,509,395.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,509,395.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(21,364,782.26)	87,372,102.36
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	589,877,803.31
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		589,877,803.31
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(589,877,803.31)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(21,364,782.26)	(502,505,700.95)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>59,061,070.31</u>	<u>643,087,912.86</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,061,070.31	148,271,112.86
120	Нийтлэг татварын бус орлого	59,061,070.31	148,271,112.86
120002	Хүүгийн орлого		87,038.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		138,114,188.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		138,114,188.00
120009	Бусад орлого	26,171,070.31	10,069,886.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,890,000.00	494,816,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		275,868,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		275,868,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,890,000.00	218,948,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,890,000.00	218,948,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>44,489,120.29</u>	<u>650,590,641.77</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	44,489,120.29	650,590,641.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,489,120.29	647,581,246.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,650,139.00	161,692,506.30
210101	Үндсэн цалин	7,650,139.00	143,118,378.88
210102	Нэмэгдэл		10,476,737.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт		5,550,000.00
210104	Урамшуулал		1,226,651.40
210105	Гэрээт ажлын хөлс		1,320,738.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,100,435.29	42,810,430.77
210201	Тэтгэврийн даатгал	2,100,435.29	24,878,881.39
210202	Тэтгэмжийн даатгал		3,243,575.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,082,012.00
210204	Ажилгүйдлийн даатгал		2,655,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал		10,950,962.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,031,386.00	14,591,979.00
210301	Гэрэл, цахилгаан		1,418,869.00
210302	Түлш, халаалт	3,031,386.00	12,867,852.00
210303	Цэвэр, бохир ус		305,258.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,238,350.00	11,383,589.00
210401	Бичиг хэрэг		2,109,650.00
210402	Тээвэр, шатахуун	2,262,250.00	5,433,467.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,126,412.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		55,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		475,610.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	4,976,100.00	1,182,500.00
2105	Нормативт зардал	-	100,000.00

210502	Хоол, хүнс		100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	13,705,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		74,900.00
210604	Урсгал засвар		13,630,700.00
2107	Томилолт, зочны зардал	-	3,874,333.48
210702	Дотоод албан томилолт		3,874,333.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,468,810.00	394,018,408.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,106,670.00	387,262,906.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		576,298.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		287,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		83,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,118,400.00
210807	Газрын төлбөр		128,800.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		62,004.04
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	362,140.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,404,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		5,404,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,009,395.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,509,395.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,509,395.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>14,571,950.02</u>	<u>(7,502,728.91)</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	39,478.89	-
140007	Хүлээн авсан хүүний орлого	39,478.89	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,098,700.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,098,700.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	7,098,700.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,098,700.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,059,221.11)</u>	=
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	7,512,728.91	(7,502,728.91)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,512,728.91
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,512,728.91	10,000.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,140,849,243.29	-21,364,782.26	1,119,484,461.03
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,140,849,243.29	-21,364,782.26	1,119,484,461.03
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,140,849,243.29	-21,364,782.26	1,119,484,461.03
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,140,849,243.29	-21,364,782.26	1,119,484,461.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,140,849,243.29	-21,364,782.26	1,119,484,461.03
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	-502,505,700.95	(502,505,700.95)
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,140,849,243.29	-523,870,483.21	616,978,760.08

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	275,868,400.00	273,359,004.82	(2,509,395.18)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	275,868,400.00	273,359,004.82	(2,509,395.18)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	275,868,400.00	273,359,004.82	(2,509,395.18)
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,578,600.00	6,612,867.00	(1,965,733.00)
210301	Гэрэл, цахилгаан	816,500.00	572,630.00	(243,870.00)
210302	Түлш, халаалт	7,601,100.00	5,900,206.00	(1,700,894.00)
210303	Цэвэр, бохир ус	161,000.00	140,031.00	(20,969.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	7,004,000.00	6,986,268.00	(17,732.00)
210401	Бичиг хэрэг	1,829,800.00	1,823,850.00	(5,950.00)
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	2,996,800.00	(3,200.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,842,000.00	1,836,418.00	(5,582.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	332,200.00	329,200.00	(3,000.00)
2105	Нормативт зардал	100,000.00	100,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,311,400.00	9,297,300.00	(14,100.00)
210601	Багаж, техник, хэрэгсэл	866,800.00	830,300.00	(36,500.00)
210604	Урсгал засвар	8,444,600.00	8,467,000.00	22,400.00
2107	Томилолт, зочны зардал	3,600,000.00	3,427,400.00	(172,600.00)
210702	Дотоод албан томилолт	3,600,000.00	3,427,400.00	(172,600.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	242,274,400.00	241,935,169.82	(339,230.18)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	237,034,800.00	236,878,519.82	(156,280.18)
210803	Даатгалын үйлчилгээ	526,800.00	521,350.00	(5,450.00)
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,000.00	287,000.00	(3,000.00)
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	30,000.00	(14,000.00)
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,250,000.00	4,089,500.00	(160,500.00)
210807	Газрын төлбөр	128,800.00	128,800.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	5,000,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	275,868,400.00	275,868,400.00	-
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	275,868,400.00	275,868,400.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	275,868,400.00	275,868,400.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	15.	18.	3.
620001	Удирдах ажилтан	3.	3.	-
620002	Гүйцэтгэх ажилтан	12.	12.	-
620003	Үйлчлэх ажилтан	-	3.	3.

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		374,722,241.77
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		374,722,241.77
Бараа, үйлчилгээний зардал		374,222,241.77
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		7,979,112.00
Гэрэл цахилгаан		846,239.00
Түлш, халаалт		6,967,646.00
Цэвэр, бохир ус		165,227.00
Хангамж, бараа материалын зардал		4,397,321.00
Бичиг хэрэг		285,800.00
Тээвэр (шатахуун)		2,436,667.00
Шуудан холбоо, интернэтийн төлбөр		289,994.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		55,950.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс		146,410.00
Аж ахуйн материал худалдан авах зардал		1,182,500.00
Эд хогшил худалдан авах		4,408,300.00
Урсгал засвар		4,408,300.00
Томилолт, зочны зардал		446,933.48
Дотоод албан томилолт		446,933.48
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		356,586,175.29
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		354,887,323.25
Даатгалын үйлчилгээ		54,948.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,500,000.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо		53,000.00
Мэдээллийн технологийн зардал		28,900.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		62,004.04
Бараа үйлчилгээний бусад зардал		404,400.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		404,400.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		500,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		500,000.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		500,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		367,219,512.86
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		367,219,512.86
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		138,114,188.00
Бусад		10,156,924.86
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		218,948,400.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		7,512,728.91
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		10,000.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2020/32/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ		мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийг ашиглалтын хугацааны нь туршид шулуун шугамын аргаар тогтмол дүнтэй элэгдүүлэхээр ХХААХҮ салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын НББ-ийн бодлогын баримт бичигт заасан. Тавилга эд хогшил, тоног төхөөрөмж дансдын тайлант үеийн элэгдлийг аудитор давтан тооцоолж үзэхэд үйлчлүүлэгчийн тайлант үеийн элэгдлийн зардлаас нийт 9,386.4 мянган төгрөгөөр бага байна.	9,386.4	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Я.Болдбаатар
2	1. Жолоочийн тооцооны хуудсыг жолооч хөтөлж хариуцах ажилтнаар явсан км-ээ баталгаажуулсан байна. Гэвч нягтлан бодогч жолоочийн тооцооны хуудсыг ашиглаж шатахууны зарцуулалтыг гаргаагүй ба жолоочтой тооцоо боддоггүй. 2. Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тогтоолд зааснаар үйлчлүүлэгч байгууллага 2500 см3-ээс дээш цилиндрийн багтаамжтай машиныг хот дотор ашиглах хориотой байна. Тус байгууллага 4500 см3 багтаамжтай Ланд круйзер 100 машиныг зарим өдрүүдэд хот дотор ашигласан байна. 3. Тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний сангаас үйлчлүүлэгчийн нэр дээр байдаг 2 машинд торгууль байгаа эсэхийг шалгаж үзэхэд нийт 956.2 мянган төгрөгийн торгуулийг төлөөгүй байгаа мэдээлэл гарч ирсэн.	5.408.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Я.Болдбаатар
3	2019 оны санхүүгийн тайлангийн биет бус хөрөнгийн бүлэгт 2018 оноос өмнө ашиглаж байсан Leader, 2019 оны санхүүгийн тайлангаа бэлтгэсэн Acolous програмууд бүртгэлтэй байна.	1,000.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Я.Болдбаатар
Дүн		15,794.4			